

Доктор (Ph.D), МУИС-ийн дэд профессор Д.ТУНГАЛАГ
МУИС-ийн Философийн тэнхмийн багш

2.9. ОЮУН САНААНЫ ҮЗЭГДЛҮҮД БА ЗАН СУРТАХУУН, ТЭДГЭЭРИЙН ХАРИЛЦАН ХАМААРЛЫН ТАЛААРХИ ОРЧИН ҮЕИЙН ҮЗЭЛ

Түлхүүр үг: *сэтгэц, зөн билэг, сэтгэл, ид, оюун ухаан, эго, ухамсар, супер-эго, ухамсаргүй сэтгэл, либидо, зан авир, ганцаардал*

Нийгэм хөгжихийн хирээр хүмүүсийн оюун санааны үзэгдэлд /сэтгэц, сэтгэл, оюун ухаан, ухамсар, ёс суртахуун, зан авир г.м/ өөрчлөлт орж, энэ нь хувь хүмүүсийн төдийгүй нийгмийн амьдралд янз бүрээр нөлөөлөх болж байна.

Хэдийгээр сэтгэл, оюун ухаан, ухамсар хэмээх ойлголтууд нь өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой, бие даасан шинжүүдтэй, философи, сэтгэл судлал, анагаах ухаан зэрэг шинжлэх ухааны судалгааны объект болж байдаг боловч тэдгээрт ижилсэх, нэг нь нөгөөдөө багтах, нэг нь нөгөөгийнхөө суурь болох зэрэг уялдаа холбоо байдаг. Үүнтэй уялдан сэтгэл, оюун ухаан, ухамсар зэрэг оюун санааны үзэгдлүүд нь хувь хүний ёс суртахуун, зан суртахуунд нөлөөлдөг үү? Эдгээрийн хооронд харилцан хамаарал бий юу? Зан авир нь хүний сэтгэлийн илрэл мөн үү? Хүний зан авир, ёс суртахууны төлөвшилд сэтгэл, оюун ухаан, ухамсрын аль нь гол үүрэг гүйцэтгэх вэ? Оюун ухаантай хүн бүр ёс суртахуунлаг байх уу? г.м. олон асуудал эрдэмтэн судлаачдын анхаарал татсаар ирсэн.

Иймээс эдгээр асуудалд тодорхой хэмжээгээр холбогдох орчин үеийн зарим эрдэмтэдийн үзэл сургаалд анхаарлаа хандуулахыг зорилоо. Хүний амьдрал нь оюун санааны болон ухамсарын амьдралд тулгуурладаг. Нийгмийн амьдралын үйл явц оюун санааны агуулгатай учраас хувь хүний оюун санааны амьдралаас урган гарна¹. Орчин үед хувь хүний сэтгэл, оюун ухаан, ухамсарын амьдралыг тайлбарласан Структурализм, Бихеворизм, Гештальт сэтгэл судлал, Фрейдизм, Неофрейдизм зэрэг олон чиглэлүүд байдаг. Тухайлбал, *структурализмын* төлөөлөгч У.Джемсийн үзэлд Ч.Дарвины байгалийн шалгарлын онол хүчтэй нөлөөлсөн юм. Иймээс тэрээр байгалийн шалгарлын явцад явцад амьтны зан үйлээс гагцхүү хамгийн ашигтай нь халгалагдан үлдэж улмаар дараагийн үед дамждаг. Нүд, чих, гар, хөл, хумс зэрэг бие махбодийн эрхтнүүд нь ашигтай үйлдэл хийдгийнхээ хувьд байгалийн шалгарлаар шилэгдэн үлджээ. Үүнтэй адилаар хүний ухамсар нь түүний түүхэн хөгжлөөс илт харагдаж байна. Ухамсартай оюун ухаан хүнд зөв оновчтой сонголт хийх боломж

олгон улмаар үе дамждаг гэж үзжээ. Ийнхүү структуралистууд ухамсарын бүтцийг судлахад гол анхаарлаа хандуулж байсан бол бихевиористууд яагаад хүний зан байдал, араншин илрэх болов гэдэгт анхаарлаа хандуулж байв. Үүнд л бүтцийн болон үйл ажиллагааны онолуудын хоорондын ялгаа оршиж байна.

Бихевиоризмын гол төлөөлөгч А.Бандура хүний хүрээлэн буй орчин нь түүний зан төлөвийг тодорхойлдог бөгөөд зан төлөв нь эргээд орчиндоо нөлөө үзүүлдэг² гэж үзэж байлаа. Тэрээр хувь хүний онцлогт хүрээлэн буй орчин, зан төлөв сэтгэл зүй ихээхэн нөлөөдөг бөгөөд сэтгэл зүйн үйл явц нь хүний оюун ухаан, хэл яриагаар тодоройлогддог гэжээ. Бандурагийн онолд хүн өөрөө өөрийгөө эзэмдэх /өөрийн хяналт ДТ/, зохицуулах явдлыг тодорхой авч үзсэн байдаг. Тэгэхдээ хүн тодорхой зорилготой амьдарч /ухамсартай ДТ/ чадвал идэвхи нь улам дээшилдэг гэсэн дүгнэлтэнд хүрсэн байна.

Хүний зан араншинд үг, хэл яриа, биеийн хөдлөл, дуу чимээ анхаарлын төвд орж ирэх үед өөрчлөлт ордог болохыг *гештальт* сэтгэл судлалыг үндэслэгчид олж тогтоон эдгээр өөрчлөлтөд нүүр царайны хувиралт, үгийн интонаци, өгүүлбэрийн бүтэц биеийн хөдөлгөөн дохио зангаа, биеэ эзэмдэх байдал зэрэг ордог хэмээн үзэж байлаа.

Хувь хүний сэтгэц, оюун ухаан, ухамсрын асуудлыг өвөрмөц байдлаар авч үзсэн чиглэл бол *фрейдизмын* чиглэл юм. Фрейдизмын гол төлөөлөгч З.Фрейд хүний сэтгэц, оюун ухааны амьдралд ухамсаргүй хэмээх ойлголтыг анх дэвшүүлж хүн нь ухамсартай үйлээр удирдагддаггүй, харин ухамсаргүй үеийн шаардлагад захирагддаг гэж үзсэн байна. Тэрээр ухамсаргүй үеийн өдөөлт, шаардлага, хэрэгцээг задлан шинжилснээр хүний хэвийн бус араншин, төрх байдал, зан чанар, шинж байдлыг тайлбарлах боломжтой гэдэгт итгэлтэй байлаа. З.Фрейд хүний зан авирын шалтгааныг нийгмийн нөхцөл байдалд нь бус харин биологийн талаас нь буюу тодруулж хэлбэл, зөн билгийн талд нь анхаарлаа хандуулж байв. З.Фрейд ухамсарыг зөн билгээс доогуур авч үзэн, хүний сэтгэхүйг иррационал мэдэрхүйн хүчнүүд удирддаг учраас нийгмийн хүчин зүйл огт хамаагүй, хүн нийгэмтэй байнгын дайсагнах харьцаатай байдаг. Хүний ухамсар, оюун санаа нь зан байдлын учир шалтгааныг өөртөө агуулж байдаг гэж үзэж байжээ. Хэрвээ зан заншил, хорио цээр, дүрэм журам зэрэг нь хүний дур хүсэлд нөлөөлбөл дур хүсэл өөрөө ухамсаргүйд шахан зайлуулагддаг. Өөрөөр хэлбэл, ухамсарт дарагдсан хүсэл бодлыг ухамсаргүй нь нуун хадгалах үүрэгтэй. Гэсэн ч ухамсаргүйд буй дур хүсэл ханамж авахын тулд ямар нэг

арга замыг хайдаг. Энэ нь алдаатай үйлдэл, сүсэг бишрэл, үг яриа нь хурц тод болох, ургуулан бодох зэргээр илэрдэг байна. Фрейдийн үзлээр ухамсраас зайлуулагдсан дур хүсэл нь ухамсаргүйд оршдог бөгөөд хүний сэтгэц нь ухамсаргүй, ухамсарын өмнөх, ухамсар гэсэн гурван хэлбэртэй болно.

Ухамсаргүй нь хүний зан авирт голлох үүрэгтэй байдаг сэтгэцийн нэг хэсэг бөгөөд сэтгэцийн энергээр цэнэглэгдсэн, интуитив шинжтэй дур хүсэл, богино хугацаанд илэрдэг сэтгэлийн хөдөлгөөн /аффектив/-ний орон зай юм³ гэж үзсэн байна. Ухамсарын өмнөх тогтолцоо нь ухамсар луу хүлээн авах бололцоотой зүйлүүд /сэтгэл догдлол, үзэл санаа, хүсэл бодол/-ийг нэвтрүүлдэг. Эдгээр нь ухамсар луу маш амархан шилждэг бөгөөд энэ нь хүний санаа сэтгэл, ёс суртахуун, нийгмийн ухамсарын хосолмол хэлбэрээр илэрдэг. Ухамсар нь голдуу дотоод ертөнцийн тааламжтай буюу тааламжгүй дур хүсэлтэй холбоотой мэдрэмжүүдээс хамаардаг гэжээ. Ийнхүү Фрейд төрөлхийн зөн билиг нь ухамсартай нөхцөлдөн хүний төрх байдлыг илэрхийлдэг хэмээн үзжээ.

Эго төлөв байдлын талаархи психоаналитикийн үзлийг В.Райх үргэлжлүүлсэн боловч Фрейдийнээс арай өөрөөр илэрийлсэн. Тэрээр хүний зан авирт бие махбодийн байдал нөлөөлдөг болохыг нотолж түүнийгээ "бие махбодийн хуяг" гэж нэрлэсэн. Түүнчлэн аливаа хорио цээрийг бий болгоход нийгэм ямар үүрэгтэй, энэ нь хувь хүний зөн билигтэй хэрхэн холбогддог талаар авч үзсэн байдаг. Зан авир гэдэг нь ямар ч нөхцөлд хүнээс илэрч буй ердийн байдал, ухамсарт харилцаа, үнэт зүйлс, ичимхий, түрэмгий зэрэг зан байдлын хэлбэр, хөдөлгөөн г.м хүнд зуршсан зүйлийг багтаадаг⁴ хэмээн Райх үзэж байлаа.

Харин бие хүний бүтцийн нэг гол хэсэг нь Фрейдийн үзэж байсан ухамсаргүйн Ид бус харин өөрийн бодгалийн хадгалан өөрийнхөө хөгжлийн зүй тогтлоор хөгжиж буй Эгогийн ухамсарлагдсан хэсэг гэж Э.Эриксон үзжээ. Тэрээр хувь хүний хөгжилд нийгмийн орчин, амьдралын явц дахь бие хүний бүтээлч байдал голлох үүрэг гүйцэтгэнэ. Бие хүний хөгжил насан туршид нь явагдаж байдаг бөгөөд үүнд зөвхөн эцэг эх, ойр дотнын хүмүүс, найз нөхөд хамт олон нийгэм бүхэлдээ нөлөө үзүүлдэг гэжээ. Тэрээр бие хүний Эгогийн хөгжлийг найман үе шат болгон ангилж нэг үе шатнаас нөгөөд шилжихдээ өөрийгөө ухамсарлах замаар зан авираа төлөвшүүлэх бололцоогоор хангаж байдаг. Гэхдээ үүнд байнга зөрчил, хямрал дагалдаж байдаг бөгөөд тухайн хүний хувьд зөрчил, хямралыг хэрхэн давж шийдвэрлэж байна гэдгээс хамаарч хөгжлийн дараагийн шатанд шилжих нөхцөл бүрдэнэ. Хэрвээ тааламжтай

нөхцөл бүрдвэл чадварлаг бие хүн төлөвшинө, зөрчил нь шийдвэрлэгдээгүй бол бие хүний зан авирт сөрөг байдал бий болно⁵ гэж үзжээ.

Эриксоны үечлэл нь Фрейдын ангилалтай төстөй боловч тэрээр биологийн буюу бэлгийн хүчин зүйлд нь бус харин нийгмийн хүчин зүйлд нь илүү ач холбогдол өгсөн байна. Ингэснээрээ тэрээр бие хүн болж төлөвших үйл явц насанд хүрсэн үеэр дуусдаггүй харин амьдралын бүхий л мөчлөгт үргэлжилдэг гэж дүгнэсэн байдаг.

Ийнхүү сэтгэл, ухамсар, оюун санааны асуудлыг бие хүний зан авирын төлөвшилтэй холбон янз бүрийн байр сууринаас өөр өөр үзэл бодлоор тайлбарлаж байсан урсгал чиглэлийн нэг нь *неофрейдизм* юм. Хэдийгээр неофрейдизм Фрейдын онолд тулгуурлан гарч ирсэн боловч түүнд дүн шинжилгээ хийж өөрийн онол сургаалаа боловсруулсан. Неофрейдизм үүсэн хөгжихөд тухайн үеийн нийгмийн байдал хүчтэй нөлөөлсөн байна. Нийгэм-эдийн засгийн хямралаас үүдэлтэй хүмүүсийн дунд бий болсон айдас, түгшүүр, амьдралд итгэх итгэл алдрах зэрэг сэтгэл санааны хямрал нь тэдний зан авирын өөрчлөлтөд нөлөөлж байжээ. Иймээс неофрейдизмын гол зорилго нь хүмүүсийн сэтгэл санааны хямралын учир шалтгааныг нарийвчлан судлах, нэгтгэн дүгнэхэд чиглэгдэж байв.

3.Фрейд хүний сексийн амьдралыг илүүтэй авч үзэж байсан бол неофрейдизмын гол төлөөлөгч А.Адлер хүний мэдрэмжид илүү анхаарч байв. Адлер аливаа хүнд өөрийгөө бусдаас ямар нэг талаараа дутуу гэдгээ мэдрэх мэдрэмж, өөрөө бусдаас илүү байгаагаа мэдрэх мэдрэмж, нийтлэг буюу тэгш мэдрэмж гэсэн гурван мэдрэмж байдаг. Өөрийнхөө сул дорой байдлыг мэдрэх нь бие хүний хөгжил, зан суртахууны төлөвшилд бэрхшээл учруулдаг. Харин түүнийгээ даван туулах оролдлого нь багадаа ээрүү байсан Демосфен нэрт илтгэгч болж, намхан Наполеон нэрт жанжин болдог шиг түүний үйл ажиллагааны тэмүүллээс хамаарна. Дутуугаа нөхөж /компенсаци/ байхгүй бол хүн хөгжихгүй зөвхөн компенсацийн үр дүнд л бие хүн төлөвшиж нийгэмд байр сууриа /ДТ/ эзэлнэ. Үүнд гэр бүл их үүрэгтэй, харамсалтай нь зарим гэр бүл энэ үүргээ биелүүлдэггүй. Хэрэв хүн өөрийнхөө дутуу гэж үзэж байсан зүйлээ сэтгэлээрээ нөхөж чадвал түүнийг даван туулж болно гэж Адлер үзэж байв.

Түүнээс гадна Адлер амьдралын зорилго, амьдралын хэв маягийн тухай ойлголтыг бий болгож, "амьдралын хэв маяг" хэмээх ойлголтыг хувь хүн буюу "Би" гэсэн ухагдахуунтай адилтган үзээд хүний "Би" нь хувь хүний амьдралын төлөвшлийн явцад бий болдог⁶ гэжээ. Түүнийхээр амьдралын хэв маягийг бүрдүүлэхэд хүний

өссөн ахуй, орчин нөлөөлдөг. Хүнийг нийгмийн харилцааны гадна авч үзэж хэрхэвч болохгүй. Учир нь нийгмийн хэрэгцээ сонирхол нь хүмүүсийн хоорондын харилцаа холбоогоор буюу мэргэжил, хайр сэтгэл болон гэр бүлийн харилцаагаар илэрч байдаг.

Хувь хүн бүр амьдралынхаа явцад гурван үндсэн зорилттой тулгардаг. Энэ нь ажил хөдөлмөр, үерхэл нөхөрлөл, хайр дурлал бөгөөд эдгээр нь хүн төрөлхтний оршин тогтнохын үндсэн нөхцлөөр тодорхойлогддог. *Ажил хөдөлмөр* нь бидэнд зөвхөн орлого өгч байгаа зүйл биш, хувь хүнд төдийгүй нийгэмд хэрэгтэй бүхий л үйл ажиллагаа юм. Ажил хөдөлмөр нь хүнд хэрэг болж буй тэр хэмжээгээрээ хүнд өөрт нь тааламжтай мэдрэмжийг бий болгодог. *Үерхэл нөхөрлөл* нь биднийг бусадтай холбож байгаагийн илрэл юм. *Хайр дурлал* нь оюун ухаан, бие махбодийн хоорондын нягт холбоо эсрэг хүйстэй хоёр хүний дундах агуу их хоршил юм. Хайр дурлал нь хүмүүст өөрсдийн үр удмаа үлдээх, амьдралыг үргэлжлүүлэхэд чиглэгдэж байдаг. Эдгээр гурван зорилт нь хоорондоо үргэлж холбоотой байдаг бөгөөд нэг зорилтыг шийдсэнээр бусад нь шийдэгддэг. Өөрөөр хэлбэл, Адлерийнхаар бүх зорилт нь хувь хүнийг төлөвшүүлэх, хүний амьдралыг хөгжүүлэн бэхжүүлэхэд зайлшгүй чухал нөхцөл болдог байна.

Анхандаа Фрейдын үзэл, онолыг дэмжиж хамтран ажиллаж байсан К.Юнг хожим үзэл санааны хувьд зөрөлдөх болсон. Үүний гол шалтгаан нь "либидо", "ухамсаргүй"-н сексийн асуудал юм. Түүнийхээр "либидо" гэж амьдралын эрчмийг илэрхийлж байгаа сэтгэцийн энерги юм. Харин секс бол үүний зөвхөн нэг хэлбэр юм гэжээ. К.Юнгийнхээр хүний зан төрхийн үндэс нь "хувийн ухамсаргүй" бус харин "хамтын ухамсаргүй" юм. Хувийн ухамсаргүй нь амьдралын туршлагаар төлөвшиж, агуулгыг нь тодорхойлдог бол хамтын ухамсаргүйд нийгмийн туршлага буюу соёлоор тодорхойлогдон зан байдал, сэтгэхүй, мэдрэмжийн онцлогийг тодорхойлдог байна. Тэрээр цааш нь хүний сэтгэцийг хувийн ухамсартай буюу хувийн ухамсаргүй, оюун санааны буюу сэтгэлийн гэсэн давхрагуудад хуваан үзжээ. Хувийн ухамсартай нь Бие хүн, Эго гэж хуваагдана. Хувийн ухамсаргүйд бүх л мартагдсан зүйлүүд /ухамсаргүй туршлага/ орно. Хамтын ухамсаргүй гэдэг нь өнгөн дээд давхрага бөгөөд төлөвшиж буй бие хүн юм. Эцэст нь оюун санаа буюу сэтгэлийн давхрага байна. Хамтын ухамсаргүй нь хүний биологийн өнгөрсөн туршлага, бодгалийн хөгжил түүний ухамсараас үл шалтгаалах мөн чанартай бөгөөд архетипаас тогтоно. Архетип нь индуктив шинжтэй, бэлгэ тэмдгийн хэлбэрээр илэрдэг ухамсаргүйн өдөөгч сэдэл,

ухамсаргүйн хэл, хүний төрх байдлын сэдэл болдог бөгөөд энэ нь зүүд, үлгэр домог, шашнаар илэрдэг⁷ гэж бичжээ. К.Юнгийн хамтын ухамсаргүй нь З.Фрейдын Эдипийн комплекстай олон талаараа ижил учир З.Фрейдын үзлээс нэг их ялгардаггүй.

Харин К.Хорни Фрейдийн либидо, Эдипийн комплексийг эсэргүүцэн гарч ирсэн. Тэрээр хүний зан авирын хөдөлгөгч хүч нь ухамсаргүй сэтгэцийн хүч гэж үзэж байлаа. Хэдийгээр Корнигийн үзэл баримтлал нь Фрейдийн онол дээр тулгуурласан боловч түүнтэй олон зүйл дээр санал зөрж байлаа. Ялангуяа нийгэм, соёлын хүчин зүйлийг авч үзэхдээ “соёл нь сэтгэцийг тодорхойлдог” гэсэн өрөөсгөл дүгнэлтэнд хүрсэн. Цааш нь Хорни бодгалийн зан авирын тухай асуудлыг “Би-гийн дүр” хэмээх ойлголтонд тулгуурлан тайлбарласан. Түүнийхээр “Би-гийн дүр” нь бодит Би, төгс Би, Би бусад хүмүүсийн нүдээр г.м. дүрээс бүрдэнэ. Хэрвээ дээрхи гурван дүр давхцсан тохиолдолд тогтвортой зан авир бүхий бие хүний тухай ярьж болох юм. Хэрвээ төгс Би-нь бодит Би-гээс ялгаатай бол хүн өөртөө эерэг сайнаар хандаж чадахгүй, түгшүүр, дарамт, өөртөө итгэлгүй байдлыг бий болгож энэ нь зан төрхийг өөрчилдөг. Би, бусад хүмүүсийн нүдээрх Би хоёр өөр хоорондоо нийцэхгүй тохиолдолд бусад хүмүүс түүнийг сайн муугаар бодож байгаагаас ч илүү өөрийнхөө тухай хэрхэн бодож байгаа нь илүү нөлөөлдөг бөгөөд энэ нь зан авирт нь бүр ч муугаар нөлөөлдөг. Үүнээс зайлсхийхийн тулд тэрээр Фрейдын нэгэн адил сэтгэл зүйн хамгаалалтыг бий болгох хэрэгтэй⁸ гэж үзсэн. Харин тэгэхдээ Фрейд Ид болон Супер-Эго хоёрын дундаас үүсч буй дотоод зөрчлийг шийдвэрлэхэд сэтгэл зүйн хамгаалалт нь тусалдаг гэж үзэж байсан бол Хорни сэтгэл зүйн хамгаалалт нь хүн-нийгэм хоёрын хоорондох зөрчлийг шийдвэрлэх үүрэгтэй гэж үзсэн. Гол зорилго нь хүнээс өөрийнхөө талаархи бодол болон хүрээлэн буй хүмүүсээс түүний талаархи бодол хоёрыг нийцүүлэхэд оршино. Ямар ч тохиолдолд өөрийгөө зөвөөр ойлгох, мэдэх, төлөвшүүлэхэд сэтгэл зүйн хамгаалалт зайлшгүй хэрэгтэй гэж үзэж байлаа.

Неофрейдизмын гол төлөөлөгч Э.Фроммын бусад психоаналитикчдаас ялгагдаж байсан гол ялгаань бие хүний зан авирын төлөвшлийн үндсэн нөхцөл, гол хүчин зүйл нь нийгэм гэж үзсэн явдал. Тэрээр Фрейдийн “либидо”-гийн онолыг төдийлөн эсэргүүцээгүй ч хүний хөгжлийн сэтгэл зүйн болон нийгмийн харилцааны хүчин зүйлүүдийг хөндөж тавьсан.

Фромм үзэхдээ хүн эволюци хөгжлийнхөө явцад өөрийн онцлог шинжтэй болж бодгальчилагддаг. Энэ нь бие хүн, нийгмийн ахуйтай тогтмол харилцаа холбоонд байдгаар тодорхойлогдоно. Ингэж бодгаль хүн болсны үр дүнд ганцаардал бий болж

өөрийгөө үгүйсгэх мэдрэмж бий болдог. Орчин үеийн хүн нь машины эрэг боолт шиг болж байна. Иймээс хүнд өөртөө итгэх итгэл алдагдаж үл итгэх байдал бий болно. Эндээс л хүний сэтгэл зүйн болон нийгмийн хүчин зүйлүүдийн хоорондын харилцан холбооны гол асуудал урган гарч байгаа юм гэж үзсэн. Иймээс психоаналитикчдын гол зорилго нь ганцаардлыг даван туулах арга хэрэгслүүдийг бий болгоход чиглэгдэж байв. Иймээс тэрээр “үүнийг зөвхөн психоаналитик аргыг хэрэглэснээр шийдвэрлэж болно” гэж үзэж байлаа. Хүн ганцаардал, хүч дорой байдлаас аврагдахын тулд эхлээд нийгэмд хэрэгтэй зан чанартай бие хүний дүр төрхийг эзэмшинэ, дараа нь дотоод сэтгэцийн механизмд шилжиж, эцэст нь нийгмийн үзэгдлийг бий болгоно хэмээн тодорхойлжээ.

Э.Фромм зан авирыг бие хүний бүхий л үйлдэлд сэтгэлгээ мэдрэмжийг бий болгодог ухамсаргүй механизмуудын цогц гэж үздэг. Түүний үзлээр хүн нийгмээс үзүүлж буй дайралтуудаас хамгаалахын тулд сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийн тогтолцоог бий болгох ёстой. Хүний зорилго нь өөрийгөө хамгаалах болон уг дайралтыг өөртөө ашигтайгаар эргүүлэх явдал юм. Хүн өөрийнхөө буруугүйг хамгаалсан хамгаалах механизмыг /Би-гийн хамгаалах механизм/ сэтгэлийн хөдөлгөөнөөрөө өөртөө бий болгодог. Ийм байдал нь яваандаа мазохизмыг үүсгэж болзошгүй. Учир нь дарангуйллын эсрэг хүмүүсийг дарангуйлах тааламжтай байдлыг өөртөө бий болгоно. Ийм хүний зан авир тогтворгүй болдог. Үүний эсрэг дарангуйллыг эсэргүйцэх байдал нь хэрцгий зан авирыг бий болгох талтай. Энэ нь садист занг бий болгох үндэс болдог. Харин хайр дурлал нь хүмүүст тусгаарлагдсан болон холдсон мэдрэмжийг даван туулах боломжийг олгоно. Хайр дурлал нь хүнд байдаг идэвхитэй хүч юм. Энэхүү хүч нь хүнийг хүнээс тусгаарладаг ханыг нэвтэлж, бусадтай нэгтгэдэг юм гэж бичиж байлаа.

Ийнхүү орчин үеийн сэтгэгчид хэдийгээр цогц байдлаар биш ч гэсэн /зарим талаараа өрөөсгөл шинжтэй ч/ сэтгэл, сэтгэц, оюун ухаан, ухамсар, ухамсаргүй зэрэг оюун санааны өвөрмөц үзэгдлүүдийг хүний төрөлхтөний оюун санааны амьдралын үндэс болгон тайлбарлаж, хүний ёс суртахуун, зан авирын төлөшилт, өөрчлөлтөд нөлөөлдөг нэг чухал хүчин зүйл болгон авч үзсэн нь ёс суртахууны философит чухал ач холбогдолтой төдийгүй зан суртахууны асуудлыг тайлбарлахад сэтгэл зүйн үндэс болж байна.

Резюме

Оюун санааны өвөрмөц үзэгдлүүд болох сэтгэц, сэтгэл, оюун ухаан, ухамсар, ухамсаргүйн тухай ойлголтууд нь хувь хүний хөгжил, зан авирын төлөвшилд гүйцэтгэх үүргийг тодруулахдаа орчин үеийн сэтгэгчдийн онол, үзэл баримтлалд тулгуурлан авч үзэж, тэдгээр үзэл баримтлалуудын бие биенээсээ ялгагдах ялгаа, онцлог, зан авирын төлөвшилд биологийн болон нийгмийн хүчин зүйл ямар байр суурь эзэлдгийг дээрхи эрдэмтэд хэрхэн авч үзсэн талаар харьцуулан үзүүлэхийг хичээв.

НОМ ЗҮЙ

1. Б.Батчулуун. Философи дахь хүний асуудал. 2001.
2. Bandura A. Social Foundations of Thought and Action. 1986.
3. Фрейд З. Я и оно. М., 1924в
4. Райх. Анализ характера. 1972.
5. Эриксон Э. Идентификация: юношеский кризис. 1968.
6. Адлер А. Превосходство и социальный интерес: собрание поздних сочинений. Под. Ред. Р.Ансбахер. 1964.
7. Юнг К. Архетип и символ. 1991.
8. Хорни К. Невротическая личность нашего времени. Самоанализ. 1993.